



### Шинжээчийн тайлан

**Байгууллагын нэр:** АШУҮИС, Дархан-Уул Анагаах Ухааны сургууль

**Хөтөлбөрийн нэр:** Эм найруулагч

**Индекс:** 091602

#### Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Мөнхтуяа

Гишүүд: Б.Цэрэндолгор

С.Идэртунгалаг

2023.06.07

## **Агуулга**

Товчилсон үгийн тайлбар

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1: Хөтөлбөрийн төлөвлөлт

Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа

Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа

Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт

IV. Уулзалтад оролцогчдын нэрс

I. Багш нарын нэрс

II. Оюутнуудын нэрс

III. Ажил олгогчдын нэрс

IV. Төгсөгчдийн нэрс

V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал

VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

## Товчилсон үгийн тайлбар

CAJMS	<i>Central Asian Journal of Medical Sciences</i>
CLO	Course Learning Outcome
DOAJ	Directory of Open Access Journals
GMP	Good Manufacturing Practices
IELTS	International English Language Testing System
IF	Impact Factor
INASP	International Network for Advancing Science and Policy
IRIM	The Independent Research Institute of Mongolia
ISO	International Organization for Standardization
ISSN	International Standard Serial Number
ERASMUS	Европын холбооны санхүүжилттэй хөтөлбөр
FIP	Federation International Pharmaceutical
MNS	Mongolian National Standards
JICA	<i>Japan International Cooperation Agency</i>
OSPE	Objective Structured Practical Examination
PLO	Program Learning Outcome
PBL	Problem-Based Learning
PTEC	<i>Pharmacy Technician Educators Council</i>
R&D	Research and Development
SCORPIO	Structured, Clinical, Objective Referenced, Problem-based, Integrated and Organized
SCOPUS	Elsevier's abstract and citation database
SPICES-T	Student centered, Problem based, Integrated, Community based, Elective, Systematic, Team based
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, and Threats,
PDCA	Plan, Do, Check, Act
TICA	Tailand International Cooperation Agency
TOEFL	Test of English as a Foreign Language
TOWS	Threats, Opportunities, Weaknesses, Strengths
UMAP	University Mobility in Asia and the Pacific
UNESCO	United Nations Educational, Scientific and Cultural Organization
WOS	Web of Science

**I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт**

<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дархан-Уул Анагаах Ухааны Сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Эм найруулагч	
<b>Индекс</b>	091602	
<b>Шинжээчид</b>	Ц.Мөнхтуяа – Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн Анагаах Ухааны Сургуулийн захирал, АУ-ы доктор, дэд профессор Б.Цэрэндолгор – Эм зүйн шинжлэх ухааны их сургуулийн Эм зүйн удирдлага, зохион байгуулалтын тэнхмийн эрхлэгч, ЭЗ ухааны доктор, дэд профессор С.Идэртунгалаг - Этүгэн их сургуулийн Эм зүйн сургуулийн захирал	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	Ахлах шинжээч Б.Мядагмаа	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	<b>Хийгдсэн байх ажлууд</b>
	2023.05.30	Сургуулийн орчинтой танилцах
		Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцах
		Оюутнуудын төлөөлөлтэй уулзах
		Багш нарын төлөөлөлтэй уулзах
	2029.05.31	Ажил олгогчийн төлөөлөлтэй уулзах /цахимаар/
Төгсөгчдийн төлөөлөлтэй уулзах		
Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.		
<b>Шалгуур шаардлага /журам/</b>	БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 08 тоот тогтоолоор баталсан “Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн Магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам”-ын “Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн нийтлэг шалгуур шаардлага”	

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

---

АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС нь 1969 онд сувилагчийн курс нэртэйгээр байгуулагдан БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 207 дугаар тогтоолоор Сувилагчийн техник мэргэжлийн сургууль нэртэйгээр байгуулагдсан.

- 1969 - 1972 онд Сувилагчийн техник мэргэжлийн сургууль
- 1972 - 1978 онд Сувилагчийн сургууль
- 1978 - 1997 онд Анагаах ухааны дунд сургууль
- 1997 - 2010 онд Анагаах Ухааны Их Сургуулийн харьяа Дархан-Уул аймаг дахь Анагаах Ухааны Коллеж
- 2010 - 2014 онд Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургуулийн Дархан-Уул аймаг дахь салбар АУС
- 2014 оноос Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Дархан Уул аймаг дахь салбар АУС

Тус сургууль нь БМИҮЗ-ийн Дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэлээр 2001, 2007, 2018 онуудад амжилттай итгэмжлүүлж, цаашид сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлыг эхлүүлсэн бөгөөд чанарын менежментийн тогтолцооны олон улсын ISO9001:2015, байгаль орчны менежментийн тогтолцооны олон улсын ISO14001:2015 стандартуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эм найруулагч мэргэжлээр дипломын боловсрол олгох сургалтын эрхийг авснаас хойш 20 жилийн хугацаанд тасралтгүйгээр сургалтын үйл ажиллагааг явуулж 890 мэргэжилтэн төгсгөсөн. Тус сургуульд Хангайн бүсээс Архангай, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд, Төвийн бүсээс Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгууд, мөн Улаанбаатар хотоос элсэгчид ирж суралцдаг бөгөөд эм найруулагч мэргэжилтний эрэлт, хэрэгцээ өсөлттэй хэвээр байсаар байна.

2020 оны байдлаар Монгол улсын хэмжээнд нийт 2639 эм зүйч, 2009 эм найруулагч ажиллаж байгаа бөгөөд 2019 оны байдлаар эм зүйч, эм найруулагчийн харьцаа 1.31:1, 2020 оны байдлаар 1.24:1 буюу 10000 хүн ам тутам дахь эм найруулагчийн тоо 6.1 байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад нийт эм зүйчийн тоо 15%-аар өсөж, эм найруулагчийн тоо 13%-аар буурсан үзүүлэлттэй байна.

**Хөтөлбөрийн хүрэх үр дүн:** Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх заавал судлах 33 хичээл, сонгон судлах 15 хичээл, эмийн ургамлын, эмийн технологийн, эм найруулагчийн дадлагыг хийж гүйцэтгэсэн, мэргэжлийн чиглэлийн 8 ерөнхий чадамжийн хүрээнд 96 мэдлэг, 86 ур чадвар, 52 хандлагад төлөвшсөн, хүн амыг Монгол улсын бүртгэлд бүртгэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслээр хангах, удирдан чиглүүлэх үйл ажиллагаа явуулах чадамжтай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

### III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

#### Шалгуур I. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### 1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### Илрэл нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг харуулсан SWOT, TOWS шинжилгээ хийсэн.
- Тухайн мэргэжил, чиглэлээр олон улсад хэрхэн мэргэжилтэн бэлтгэдэг талаар судалсан. “Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод эм найруулагч мэргэжлийн хэрэгцээ шаардлага байгааг эрүүл мэндийн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөө хэсгээс тодорхойлж гаргасан.
- Мэргэжлийн эрэлт хэрэгцээтэй холбоотой Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт, олон улсын зарим судалгаанууд, эрүүл мэндийн салбарт ажиллаж буй эм найруулагч, ажил олгогчдоос авсан судалгаа зэргээс эх сурвалж авч судалгаа хийсэн байна
- Дотоод, гадаадын ижил төстэй бэлтгэдэг мэргэжлүүдтэй харьцуулсан судалгаа хийсэн. (АНУ-ын үндэсний их сургууль, Канадын Жоржиан коллеж, Фаншейв коллеж /Канад/ дипломын хөтөлбөрүүдтэй харьцуулсан судалгаанууд хийсэн.)
- Нийгмийн эрэлт хэрэгцээнд үндэслэн эм найруулагч мэргэжилтэн бэлтгэх дипломын сургалтын хөтөлбөрийг БСШУЯ-ны сайдын А/174 тоот тушаалын шалгуур шаардлагын дагуу боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.

##### Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, оролцогч талуудын санал хүсэлтийг тусгах, гадаадын ижил төстэй их, дээд сургуулиуд, коллежуудын туршлагыг нэвтрүүлэх чиглэлээр өргөн хүрээнд ажилласныг онцолж байна.
- 2017 оноос чанарын менежментийн тогтолцооны ISO9001:2015 стандартыг, 2018 оноос суралцагчдад байгальд ээлтэй хандлага төлөвшүүлж, сургалтын ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор байгаль орчны менежментийн тогтолцооны ISO14001:2015 стандартыг хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн шинэчлэлтүүдийг 2004, 2018, 2020 онд хийсэн.

##### Дүгнэлт:

- Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, олон улсын чиг хандлагыг баримжаалан оролцогч талуудын хэрэгцээг хангахуйц боловсруулалтыг хийсэн.

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн оролцогч талуудын санал зөвлөмжийг хөтөлбөрийн сайжруулалтад хэрхэн тусгасан аль эсвэл тусгах боломжгүй зэрэгт анализ дүгнэлт хийж боловсруулалт хийж, гарсан зөвлөмжийг хөтөлбөрт тусгасан эсэхийг оролцогч талуудад эргэж мэдэгдэх
- Төгсөгчид ажлын байрандаа хөгжих мэргэшүүлэх, сургалтад хамрагдах хүсэл сонирхолтой байгааг анхаарч тэдэнд чиглэсэн үйл ажиллагааг өргөтгөх
- Дотоодын бусад их дээд сургуультай харьцуулсан судалгаа хийх

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөрийн хэрэгцээнд хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгааг оруулах
- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг харуулсан шинжилгээг илүү нарийвчлан хийх (STEER шинжилгээ хийх)

### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Монгол Улсын төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсад дээд боловсрол олгох үндсэн суурь зарчмуудыг баримтлан АШУҮИС-ийн хөгжлийн бодлого, эрхэм зорилго, алсын хараа, АШУҮИС цогц чадамжтай нийцүүлэн тодорхойлсон.
- Эм найруулагч хөтөлбөрөөр төгсөгч нь суралцах хугацаандаа мэргэжлийн чиглэлээр 96 мэдлэг, 86 ур чадвар, 52 хандлага, 8 чадамжийн хүрээнд тодорхойлсон.
- Сургуулийн алсын хараа, эрхэм зорилготой нийцүүлэн, “Сургуулийг хөгжүүлэх стратегийн төлөвлөгөө 2030” хөтөлбөр 5 чиглэлээр төлөвлөн боловсруулсан.
- Олон улсын болон үндэсний бодлогын эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдсан үзэл баримтлал, шийдвэрүүдийг тусгасан.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг жил бүр гаргаж үр дүнд анализ хийдэг.
- Төгсөгчдийн мэдлэг чадварын талаарх ажил олгогчдын судалгааг жил бүр зохион байгуулж судалгааны үр дүнд үндэслэж практикт хэрэгжүүлэх цаашдын арга замыг тодорхойлох хэлэлцүүлэг хийдэг.

#### **Дүгнэлт:**

- Хөтөлбөрийн зорилго, зорилт нь Монгол Улсын төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсад дээд боловсрол олгох

үндсэн суурь зарчмууд, байгууллагын хөгжлийн бодлого, багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчдын судалгаанд нийцүүлэн тодорхойлсон.

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлийн хөтөлбөрийн хүрэх үр дүн CLO буюу мэдлэг, чадвар, хандлагыг хөтөлбөрийн үр дүн PLO-тэй хамаарлыг дахин үнэлэх.

#### **Зөвлөмж:**

- Суралцахуйн үр дүнгүүдийг хөтөлбөрийн оролцогч талуудад түгээн таниулах маркетингийг сайжруулах
- Хөтөлбөрийн суралцахуйн үр дүнг нарийн тодорхойлсон хэдий ч үр дүнд суурилсан боловсролын онол арга зүйн дагуу төгсөгчийн загвар (Graduate attributes), хөтөлбөрийн боловсролын зорилгуудыг нарийвчлан боловсруулах

### **1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- БСШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаалаар баталсан “бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг 12 шаардлагын дагуу АШУҮИС-ийн захирлын 2016 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн А/56 тоот тушаалаар батлагдсан, “ Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг зохицуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж сургуулийн захирлын 2017 оны А81 тоот тушаалаар Дархан-Уул аймаг дахь салбар АУС-ийн хөтөлбөрийн дэд хороо байгуулагдаж, бүрэлдэхүүн, ажиллах журам батлагдсан.
- 2022 оны 03-р сарын 02-ны өдрийн А/10 тоот тушаалаар сургуулийн хөтөлбөрийн дэд хорооны бүрэлдэхүүнийг ажил олгогчдын төлөөлөл, төгсөгчдийн төлөөллөөр өргөтгөж ажилласан.
- БСШЯ-ны сайдын 2014 оны А/174 дугаар тушаал батлагдсан нийтлэг 12 шаардлагыг хангасан.
- Хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа 12 бүрэлдэхүүн хэсэгтэйгээр боловсруулсан ба хичээлийн хөтөлбөрийн өмнөх болон дараах залгамж холбоог агуулга, ур чадварын хамаарлын дагуу төлөвлөн боловсруулж, хичээл нэг бүрээр тодорхой агуулгын дагуу хавтас үүсгэсэн байна.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн багш, улирал бүр судалсан оюутнаас үр дүнгийн судалгаа авч, тухайн жилийн амжилт, чанарыг өмнөх жилүүдтэй харьцуулан дүгнэлт хийдэг.
- Хөтөлбөрөөр дамжуулан хүрэх үр дүнг, агуулга, хичээлийн залгамж холбоо, сургалтын арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүн, ашиглах эх сурвалж, суралцагчийг үнэлдэг.
- Дэд хорооноос гарсан санал зөвлөмжийг хөтөлбөрийн сайжруулалтад тусгах үйл ажиллагааг тухайн мэргэжлийн тэнхим, багш нар зохион байгуулдаг.



**Дүгнэлт:**

- Оролцогч талуудын судалгаа хийж, судалгаан дээр үндэслэн хөтөлбөрийн төлөвлөлтөд тусгадаг.

**Үнэлгээ: Бүрэн хангасан****Зөвлөмж:**

- Сургалтын нэгдсэн төлөвлөгөө нь эм найруулагчийн хөтөлбөрийн үр дүн (PLO)-г дамжаа бүрд хэрхэн дэмжиж байгааг тодорхойлох шаардлагатай.

**Дүгнэлт:**

Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлж, олон улсын чиг хандлагыг баримжаалан, Монгол Улсын төрөөс баримтлах бодлого, Боловсролын тухай хууль болон Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсад дээд боловсрол олгох үндсэн суурь зарчмууд, байгууллагын хөгжлийн бодлого, багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчдын судалгаанд нийцүүлэн хөтөлбөрийн зорилго зорилтоо тодорхойлсон.

**1-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан****Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

**2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

**Илрэл нотолгоо:**

- Эм найруулагчийн дипломын хөтөлбөрийг БШУ-ны сайдын 2014 оны “Дээд боловсролын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага” А/174 тоот тушаалын дагуу боловсруулсан. Заавал судлах 33, сонгон судлах 15, мэргэшүүлэх 3 хичээлийн хөтөлбөрийг боловсруулсан.
- АШУҮИС-ийн салбар 3 сургуультай хамтарсан Эм найруулагч мэргэжилтний цогц чадамжийг сайжруулах олон улсын төсөлд хамтран ажиллаж хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, суралцагчдад цогц чадамжийг олгодог.
- Хөтөлбөрийн төгсгөлд хүрэх үр дүнг суралцагч, төгсөгч, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээр үнэлдэг.
- Сургалтын гэрээт Дархан эм холбоо (56 эмийн сан), Нахиа эмийн үйлдвэр, Тавин ус эмийн үйлдвэртэй хамтын ажиллагааны гэрээтэй бөгөөд 7 багц цагийн дадлагыг батлагдсан удирдамжийн дагуу удирдагч багш томилогдон удирдан ажилладаг.

**Онцлог зүйл:**

- Эм найруулагч хөтөлбөрөөр суралцагчдад 51 хичээлийн 234 ур чадварын шалгуураар үнэлэн сайжруулдаг. “Чадамжид суурилсан сургалт”-ыг зохион байгуулдаг.
- Мэдлэг 96, ур чадвар 86, хандлага 52 агуулгын давхцалгүй, хичээлийн уялдаа холбоотойгоор цогц чадамжийг олгодог.

#### **Дүгнэлт:**

“Эм найруулагч” мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ хичээл бүрийн хөтөлбөрийг “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу иж бүрэн боловсруулсан бөгөөд мэдлэг 96, ур чадвар 86, хандлага 52 агуулгын давхцалгүй, хичээлийн уялдаа холбоотойгоор цогц чадамжийг олгодог.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, хичээлийн хүрэх үр дүнгийн уялдаа холбоог сайжруулах
- Эм найруулагчийн хөтөлбөрийн матрицийг ойлгомжтой байдлаар томъёолох

#### **Зөвлөмж:**

- Үр дүнд суурилсан сургалтыг нэвтрүүлэх, хөтөлбөрийн хүрэх үр дүн, хичээлийн хүрэх үр дүнг тодорхой тусгах, уялдаа холбоог сайжруулах

## **2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын арга зүйг БШУ-ны сайдын 2014 оны А/174 тоот тушаал, АШУҮИС-ийн захирлын 2021 оны А/19 тоот тушаалын 2 хавсралт “Сургалтын технологи, чанарын хяналтын журам”-аар хэрэгжүүлдэг. Эм найруулагчийн дипломын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд танхимын сургалтаар зохион байгуулдаг.
- Төгсөлтийн шалгалтыг онолын шалгалтыг тестээр авдаг ба жил бүр 30%-ийг шинэчилдэг. Гардан үйлдлийн шалгалт нь 3 өртөөгөөр явагддаг.
- 2022-2023 онд UNIMIS cloud university, elearning.mnums.edu.mn сургалтын программд багшийн лекц, 1800 сорилыг байршуулсан, суралцагчдын хандалтын тоо 2300, видео 274 хичээл байгаа нь оюутнууд үр дүнтэй суралцах боломжийг олгодог.

#### **Онцлог зүйл**

- Суралцаж буй оюутан тус бүрт албан ёсны мэйл хаяг нээн төлбөр, дүнгийн мэдээллийг хүргэдэг. Мөн 3.5-аас дээш голчтой оюутны гэр бүлд талархлын захидал хүргүүлэх болон бусад холбогдох мэдээллийг хүргүүлэн эргэх холбоотой ажилладаг.

- Хичээлд идэвхтэй сургалтын аргууд, биет үзүүлэн ашиглан, оюутныг идэвхжүүлэн, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Тухайлбал, Оюуны зураглал /Загасан нуруу арга/-ын аргыг өргөн ашигладаг.
- Багшийн сурган заах арга зүйн чиглэлээр удирдамж боловсруулан, ажлууд зохион байгуулдаг. Тухайлбал, Заах арга зүйн уралдаан зохион байгуулдаг. “Анагаах ухааны боловсрол судлал” багш нарт зориулсан сургалтын гарын авлага-2017 -тай байна.

#### **Дүгнэлт:**

“Эм найруулагч” сургалтын төлөвлөгөөнд тусгасан хичээл бүрийн хөтөлбөрийг “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу иж бүрэн боловсруулсан бөгөөд хичээлийг заах технологи, арга зүй харилцан адилгүйгээр “оюутан төвтэй” сургалтыг хэрэгжүүлж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУУИС-ийн захирлын 2022 оны 05 сарын 27-ны өдрийн А/125 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын IV бүлэг “Үнэлгээний аргачлал”-ын оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэх аргачлалыг мөрддөг.
- Сургалтын хөтөлбөрт мэдлэг, чадварыг үнэлэхдээ 70 хувийг Миллерийн сонсон, харсан төвшний үнэлгээний аргууд (сорил, ам, эссэ), 18 хувийг хийсэн төвшин (туршилт, нотолгоо, дүгнэх), 12 хувийг чадсан төвшин (тайлбар бичих, найруулан бичих) аргыг хэрэглэдэг. Мөн Блумын таксономи, Рубрик үнэлгээний аргуудыг ашигладаг.

#### **Онцлог зүйл:**

- Эм найруулагч мэргэжлээр суралцаж буй 2-р дамжааны оюутнуудаас анги дэвших шалгалтыг онолын шалгалтыг тестээр, ур чадвар (Эм судлал, Эмийн ургамал судлал, Эмийн сангийн технологи гэх мэт мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл)-ын шалгалтыг үнэлгээний хуудас ашиглан авдаг.

#### **Дүгнэлт:**

- АШУУИС-ийн захирлын А/125 тоот тушаалын хавсралтад тусгасан журмын дагуу оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлдэг бөгөөд тасралтгүй сайжруулдаг байна.

#### **Дүгнэлт:**

“Эм найруулагч” мэргэжлийн сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хичээл бүрийн хөтөлбөрийг “Бакалаврын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага”-ын дагуу иж бүрэн

боловсруулсан бөгөөд оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэн оюутан төвтэй сургалтаар мэдлэг, ур чадвар, хандлага бүхий агуулгын давхцалгүй, хичээлийн уялдаа холбоотойгоор цогц чадамжийг олгодог.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан.

## **2-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургууль нь 1500 оюутны багтаамжтай хичээлийн 2 байр, лекцийн 5 заал, сургалтын 6 лаборатори, мэргэшүүлэх ур чадварын 3 танхим, 27 анги танхим, үрлэн эмийн цехтэй.
- Хичээлийн байруудыг бүрэн камержуулсан.
- Цахим хичээл бэлтгэх 2 өрөөг тохижуулсан.
- Сургуулийн хэмжээнд UNIMIS нэвтэрснээр багшийн хавтас бүрдүүлэлт, хичээл сургалттай холбоотой файлын сан үүссэн, нэгж албадуудын ажлын үзүүлэлт, явц, үнэлгээ зэрэг мэдээллийн ил тод байдал дээшилсэн.
- Оюутны дотуур байрны их засварын ажлыг улсын төсөвөөр буюу 700 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр эхлүүлсэн бөгөөд үүнд сантехникийн иж бүрэн шинэчлэл, заслын ажлууд, цахилгааны иж бүрэн шинэчлэл хийхээр төлөвлөж ажиллаж байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хичээлийн Б байрны өргөтгөл буюу спорт заал барих ажлыг 1.3 тэрбум төгрөгийн төсвөөр хийхээр “Элчит ган” ХХК тендерт шалгаран ажлыг эхлүүлсэн байна. Тус спорт заалны барилгын нийт талбай 663 м.кв хэмжээтэй, цутгамал төмөр бетон хавтан суурьтай, бүрэн цутгамал төмөр бетон ханатай, 150 мм хөөсөнцөр дулаалгатай, сүүлийн үеийн стандартын шаардлагыг бүрэн хангасан, хичээлийн Б байртай хоолойгоор холбогдсон, хувцас солих өрөө, эрэгтэй, эмэгтэй душ, багшийн өрөө, фитнес өрөө, сургалтын өрөө, сургалтын хэрэглэгдэхүүн хадгалгалах өрөө бүхий барилга байх бөгөөд заалны гадна талд машины зогсоол болон ногоон байгууламжийн асуудлыг бүрэн шийдвэрлэсэн байхаар зураг төсөл нь хийгджээ.

#### **Онцлог зүйл:**

- 2018 оноос байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 хэрэгжүүлэн ажиллаж сургуулийн гадаад, дотоод орчныг экожуулж мод тарьсан, ус, цаас, цахилгааны зардлыг хэмнэх нөхцлийг бүрдүүлсэн.
- “Хамтдаа хөгжье” оюутны санаачилгыг дэмжих төсөл хэрэгжүүлж Relaxing corner, Green heart бие даан суралцах төвийг тохижуулсан.

- 2021 онд сургуулийн гадаад үзэмжийг сайжруулан хичээлийн А байрны фасадны засварыг 90.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр хийсэн нь суралцагчдын болон багш, ажилчдын түүнчлэн орон нутгийн иргэдийн сэтгэлд нийцэж сургуулийн шинэ өнгө төрхийг бий болгосон.
- Хонгор суманд байрлах 5 га газар бүхий эмийн ургамлын полигонтой. Хашаажуулалт, худаг гарган хамгаалалтын зурваст мод суулгасан. 2 хүлэмж 6x10 хэмжээтэй 2 хүлэмж барьж артишок тарималжуулж эхэлсэн. Гэрээт агрономич ажиллуулдаг. Кориандр, сармис, артишок, хар манжин зэрэг ургамлыг тариалахаар төлөвлөж ажиллаж байна.

**Дүгнэлт:** Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори хүрэлцээтэй, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл урсгал засварын ажлыг байнга хийдэг, суралцах орчныг сайжруулах талаар оюутны санаачилга дээр суурилсан тодорхой ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Сургалтын орчинд хийсэн оюутны сэтгэл ханамжийн судалгаанд тулгуурлан, эм найруулагч хичээлийн лабораторийн хэрэглэгдэхүүнийг орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах боломжийг судлах
- Орион программ бүхий компьютерийн хангамжийг нэмэгдүүлэх
- Сургуулийн орчинд чөлөөт wifi интернет ашиглах боломжийг нэмэгдүүлэх

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Фитохимийн лаборатори байгуулахаар сокслетийн аппарат, вакум ууршуулагч, нунтаг савлагч машин, спектрофотометрийн аппарат зэрэг 29.6 сая багаж төхөөрөмжийг авч суурилуулсан.
- Сургалтын нөөц хүртээмжид сэтгэл ханамжийн судалгааг төгсөгчдөөс авдаг.
- Анги танхим бүрийг 40-75 инч бүхий дэлгэцээр тоногдсон, багш нэг бүрийг компьютер, хэвлэх төхөөрөмжөөр хангалт хийсэн.
- 2020-2023 онд нийт 48 төрлийн хичээлийн 422 цахим хичээлийг байршуулан сургалтыг зохион байгуулсан байна.

#### **Онцлог зүйл:**

- Цахим хичээлд бэлтгэх тусгай өрөөтэй болсоноор аудио, видео хичээлийн тоо олширч, контент зохион бүтээж, сургалтад ашиглах үйл явц нэмэгдсэн.
- Үрлэн эмийн цехийг эмийн туршилт судалгаа, эм найруулагчийн ангийн дадлага хичээлийг явуулах зориулалтаар тохижуулсан. Зарим нэг үрэл эмийг үйлдвэрлэж бүтээгдэхүүн гарган авсан. Тухайлбал витамин С, аньстай болон чацарганатай үрлийг үйлдвэрлэж 50ш-ээр, артишокийн навчны нунтагийг 5г-аар тус тус савлах дадлага хийдэг.

**Дүгнэлт:** Жил бүр ажил олгогчид, төгсөгч болон суралцагсдаас сургалтын орчин, чанар, хичээлийн хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, номын сангийн үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн судалгааг авч үр дүнг үндэслэн үйл ажиллагаагаа тогтмол сайжруулан ажилладаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Лабораторийн тоног төхөөрөмжүүд, үрлийн машин, спектрофотометр гэх мэт багажийн ашиглалт, паспорт хөтлөлт бүртгэлжүүлэлтийг тогтмол хийх, багаж тоног төхөөрөмж ашиглах аюулгүй ажиллагааны дүрмийг байршуулах
- Эмийн технологи гэх мэт дадлагын хичээлийн явцад хийгдсэн бүтээгдэхүүнд чанар стандартын дагууд үнэлгээ хийх, технологийн горимыг сайжруулах тал дээр багш нар хяналт тавьж ажиллах

### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургуулийн номын сан нь хичээлийн А байранд 130 хүний суудалтай 263.49 мкв талбайтай уншлагын танхимтай, оюутны байранд 54 суудал бүхий уншлагын танхимтай.
- Жилдээ 1500 нэр төрлийн 26000 ном, сурах бичгийг үйлчилгээнд гаргадаг.
- 2018-2022 онд шинээр 1801 ном, сурах бичиг худалдан авахад 71.4 сая төгрөг, монгол, гадаад хэл дээр хэвлэгдсэн 20 нэр төрлийн 224 ширхэг сэтгүүлийг худалдан авахад 5.5 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавих шаардлагад /MNS 5742:2007/ тусгагдсанаар төрөл анги, үсэг дарааллын цаасан каталог, номын сангийн LIB4U PC Version болон Коха програмуудыг ашигладаг.

**Онцлог зүйл:**

- Багш оюутнуудын хэрэгцээ, шаардлагыг үндэслэн 6 хүний суудал бүхий чөлөөт сонголттой уншлагын танхим, 8 хүний суудалтай багаар ажиллах танхимыг нээн ажиллуулснаар оюутнууд багаар ажиллахаас гадна судлаач багш нар судалгаа шинжилгээний ажлын талаар хамтран туршлага солилцох орчинг бүрдүүлсэн.

**Дүгнэлт:** Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Номын санд хэрэглэгдэж буй орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмж, дохиоллын систем суурилуулах
- Номыг ариутгах халдвартгүйтгэлийн багаж суурилуулж ашиглах

#### **Дүгнэлт:**

Эм найруулагч бэлтгэх сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын орчин барилга, байгууламж, хичээлийн анги танхим, лаборатори, номын сан нь Дээд боловсролын байгууллага байгуулахад тавигдах нийтлэг шаардлага, эрүүл, аюулгүй байдлын стандарт хангасан байна.

**Шинжээчийн үнэлгээ:** Бүрэн хангасан.

### **3-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

*Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.*

#### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн ерөнхий хороо, дэд хороог АШУҮИС-ийн захирлын 2016 оны 5-р сарын 19-ны өдрийн А/56 тушаалаар баталсан бөгөөд дэд хороог Дархан-Уул АУС бүрдүүлдэг учраас хөтөлбөрийн нэгжийн шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж буюу тэнхимийн саналыг бүрэн тусгаж ажилладаг.
- Хөтөлбөрийн хэрэгжилтэд багш, суралцагч, тэнхим гэсэн талуудын оролцоог нотлох баримтаар ирүүлсэн.
- Дархан-Уул АУС нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх урт болон богино хугацааны төлөвлөгөө гаргаж АШУҮИС-ийн стратеги, бодлого төлөвлөлтөнд өөрийн стратегийг бүрэн тусгаж чадсан. Төлөвлөгөөний биелэлтэд 2018 оны хичээлийн жилээс эхлэн гүйцэтгэл, ахиц дэвшлийн үнэлгээг хийж ирсэн.
- Суралцагчийн зүгээс санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, УМС-ээр дамжуулан явуулдаг.
- АШУҮИС-ийн ажлын хэсэгтэй хамтарч “Сургалтын чанар-багшийн хөгжил” чиглэлээр арга зүйн дэмжлэг авах сургалт авсан.
- Сургалт Хэлэлцүүлэг Үнэлгээ сэдэвт хэлэлцүүлэгт сургалтын хөтөлбөр, багшийн хөгжил, оюутны хөгжил, сургалтын орчин гэсэн 4 бүлгээр зохион байгуулдаг.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- UNIMIS-ээр дамжуулан оюутанд, багшид, захиргаа, сургалтын бодлого зохицуулах албанд мэдээлэл дамжуулах системийг бүрдүүлсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн дэд хороогоор Эм найруулагч хөтөлбөрөөр суралцагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулахтай холбоотой асуудлыг тогтмол хэлэлцэх

### **Дүгнэлт:**

- Сургалтын чанар сайжруулах зорилгоор оролцогч талуудыг хамруулсан сургалт судалгааны ажлыг зохион байгуулж үр дүнг хэлэлцэж хэвшсэн байна.

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Зөвлөмж:**

- Ажил олгогчийн саналыг хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтанд тусгах, эргэх холбоотой ажиллах тогтолцоог бүрдүүлэх

### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаа хөгжүүлж эхэлсэн, дотоодын клиникийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдийн хүрээнд хичээлийн болон мэргэжлийн дадлагыг эмийн сан, эмийн үйлдвэрт түшиглэн хийж тогтмолжсон.
- “Дархан эм Холбоо” ТББ-тай хамтын ажиллагааны гэрээ бүхий 56 эмийн санд эмийн сангийн дадлага хийдэг. Дархан нэгдсэн эмнэлэг, Орхон аймгийн бүсийн оношлогооны төв, Архангай, Сэлэнгэ, Орхон аймгийн нэгдсэн эмнэлэг, Нахиа, Тавин ус эмийн үйлдвэртэй гэрээ байгуулснаар эмийн үйлдвэрийн дадлагыг хийж эхэлсэн.
- БНХАУ-ийн Нанжин хотын түшиц эмнэлэгтэй их сургуулийн хүрээнд 3+1 хөтөлбөр хэрэгжүүлэх хамтын сургалт судалгааны чиглэлээр ажиллах тохиролцоонд хүрсэн. Гэрээ байгуулж ажилласан байна.
- БНХАУ, Тайланд улсад мэргэжил дээшлүүлэх сургалтанд Мөнх-эрдэнэ, Хулан багш нар хамрагдсан. 2017 онд Б. Хулан багш 14 хоногийн сургалтанд хамрагдсан байна. 2019 оны 3 сар Тайланд улсад сургалтанд хамрагдсан байна.
- Дархан-Анагаах төгсөгчдийн холбоо ГҮТББ нэртэйгээр албан ёсны хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ /№000131959/ бүхий төгсөгчдийн холбоотой.
- Хөтөлбөрийн дадлагын баазын зориулалтаар Хонгор суманд ургамал тарималжуулах полигоныг байгуулах үйл ажиллагааг 2018 онд эхлүүлсэн. Хашаалж тог татан, худаг гаргасан, 4Х10 хэмжээтэй сууц барьсан, 2020-2025 онд хөгжүүлэх төлөвлөгөөтэй.
- 2022 оноос артишок тарьж эхэлсэн, 2 хүлэмжтэй 6Х10 харьцаатай. Ургамал газар тариалангийн хүрээлэнд биохимийн лабораторид зарим үзүүлэлтийг тодорхойлуулсан. Сургуулийн Эрдмийн чуулганд, Эрдмийн судалгаа хийж үр дүнг танилцуулсан. Сайхан сэтгэл сэтгүүлд эмчилгээний чанар ач холбогдлын талаар өгүүлэл хэвлүүлсэн байна. 2 төсөл хэрэгжиж байна.
- Оюутны санаачилгын төслүүд хэрэгжүүлж эхэлсэн, төсөлт хөтөлбөрийг дэмжиж, оюутан багшийн судалгаа шинжилгээний ажлыг хөгжүүлж эхэлсэн. 5 төрлийн ургамал тарималжуулах, багш оюутан судалгааны ажил хийхээр төлөвлөж ажиллаж байна.

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутан суралцагчдын дунд зохион байгуулдаг сургалт семинар, үйл ажиллагаа нь бие хүний төлөвшил, ёс зүйд зонхилон анхаарсан байна.
- Төгсөгчдийн ажлын байрны нэгдсэн мэдээлэл, хамтын ажиллагааны чиглэлээр УМС-д өргөтгөл хийж байгаа.



- Багш докторантурын сургалтанд сурч буй тохиолдолд дэмжлэг үзүүлэн мөнгөн урамшуулал олгож, ажлын цагийн зохицуулалтыг хийж дэмждэг.
- Төгсөгчдийн мэдлэг чадварын талаарх ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны тайлан бичиж боловсруулсан. 2017 оноос жил бүр сэтгэл ханамжийн судалгаа авч тайлан бичдэг.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн багш нар манлайлал үзүүлэх болон нийгэмд чиглэсэн үйл ажиллагаанд суралцагчдыг татан оролцуулахад анхаарч ажиллах

#### **Дүгнэлт:**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай гэрээ хийж, багш солилцоо, хамтарсан сургалт, судалгаа, семинар хэлэлцүүлгийг хийдэг байна.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Зөвлөмж:**

- Эм найруулагч хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн багш нарын зүгээс нийгэмд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагааны тоо, цар хүрээг нэмэгдүүлэх
- Эм найруулагч мэргэжил сонгосон оюутан болоод багш солилцооны хүрээг, тэтгэлгийн хэмжээг нэмэгдүүлэх

### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дархан-Уул АУС нь санхүүгийн хувьд АШУҮИС-ийн Удирдах зөвлөлийн 2020 оны 002 тоот тогтоолоор батлагдсан “АШУҮИС-ийн дүрэм”-ийн 3.7-р зүйлд АШУҮИС-салбар сургууль, харьяа байгууллага нь бие даасан хуулийн этгээдийн эрх эдлэх бөгөөд захирлууд нь гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг их сургуулийн захиралд тайлагнаж хариуцлага хүлээлгэдэг тогтолцоотой.
- 2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилүүдэд суралцагчийн тоо цөөрсөнтэй холбоотой сургалтын төлбөрийн орлогын дүн, улмаар эм найруулагчийн хөтөлбөрт зарцуулах хувь хэмжээ буурсан.
- Эко номын сан барих төсвийг 2019 оны төсөвт суулгаж хичээлийн байрны өргөтгөлийн барилгыг 234.2 сая төгрөгийн өөрийн санхүүжилтээр байгуулсан.

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжийн зүгээс АШУҮИС-ийн жилийн нэгдсэн төсөвт өөрийн үйл ажиллагаа, хичээл практикийн зардлаа тусгуулах тогтолцоо бүрдсэн.
- 1.4 га газар, 380 вольтын цахилгаан шугамтай, 195 сая төгрөгийн барилга байгууламж, 72.6 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эко ариун цэврийн өрөө бүхий 30 ортой сувилал нээх бэлтгэл хангагдаж, төсөл бичиж тусгай зөвшөөрлийн комисст хүсэлт хүргүүлсэн.
- Сургуулийн “Сайхан сэтгэл” үүдэн эмнэлэг байгуулан 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.
- Хичээлийн Б байрны өргөтгөл Спорт заал, оюутны дотуур байранд хийгдэх их засварын ажлууд 2023 оны төсөвт 100% тусгагдсан ажлууд эхэлсэн байв.

#### **Дүгнэлт:**

Оюутны суралцах, амьдрах орчин, багаж тоног төхөөрөмж, багшийн хөгжил урамшуулал, багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг туслалцаа үзүүлдэг

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

##### **Зөвлөмж:**

- Санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал, суралцагчийн сургалтын төлбөрөөс хамааралтай байгаа тул эм найруулагч хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж оюутны сургалтын төлбөрөөс бусад санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгох (сургалт, эрдэм шинжилгээний төсөл, төсөлт хөтөлбөр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг)

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Оюутны хөтөч - оюутанд зориулсан гарын авлага, мэдээ мэдээллийг агуулсан, хөтөлбөрийн төлөвлөгөө, төлөвлөгөөт ажлуудын эмхэтгэлийг жил бүр гаргадаг.
- Суралцагчдаас сургалтын үйл ажиллагаа, сургуулийн орчин, багшийн харилцаа хандлагын талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг авдаг. Судалгаанаас гарсан үр дүнг дүгнэж сайжруулалтыг хийдэг.
- Төгсөгчдийн уулзалт болон “Багш шавийн уулзалт” үйл ажиллагааг зохион байгуулдаг.

##### **Анхаарах асуудал:**

- Эм найруулагч хөтөлбөрөөр маркетинг идэвхижүүлэлтийг тогтмол хийх, тодорхой хэмжээний санхүүжилтийг жил бүр тусгаж ажиллах

**Дүгнэлт:** Хөтөлбөрийн тогтвортой байдлаа хангах элсэгч, суралцагчдад зориулсан “Оюутны хөтөч” гарын авлага эрхлэн гаргаж, сургуулийн эрхэм зорилго, сургалтын хөтөлбөрийн үйл ажиллагааг сурталчлах түгээн дэлгэрүүлэх зорилготой ажлуудыг зохион байгуулж хэвшсэн.

#### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

##### **Зөвлөмж:**

- ЕБС-ийн суралцагч, элсэгчдэд эм найруулагч хөтөлбөрийг танилцуулах, мэргэжил сурталчлах үйл ажиллагаа тогтмол, өргөн цар хүрээгээр явуулах
- Эм найруулагч хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхим хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхижүүлэлтийн төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг жил бүрээр хянах

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Эм найруулагч хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар мэдээллийг оюутан, багш, төгсөгчид, ажил олгогчдод нийгмийн сүлжээ, сургуулийн вебсайт, багш, оюутны гарын авлага, UNIMIS, төгсөгчдийн холбооны үйл ажиллагаагаар дамжуулан мэдээлэл хүргэдэг.
- Дархан-Анагаах цахим сонин эрхлэн гаргадаг ба 6 дугаар гаргасан.

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Мэдээллийн системээр багш, суралцагч, сургуулийн захиргаа хөтөлбөрийн төлөвлөлт, хэрэгжилт, маркетингийн талаар мэдээлэл хүлээн авах, солилцох боломжтой.

### **Дүгнэлт:**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг шинэчлэн түгээдэг байна.

### **Үнэлгээ: Бүрэн хангасан**

### **ДҮГНЭЛТ:**

Сургалтын чанар сайжруулах зорилгоор оролцогч талуудыг хамруулсан сургалт судалгааны ажлыг зохион байгуулж, мөн суралцах орчин, багаж тоног төхөөрөмж, багш ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж, сургуулийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод мэдээллийг хүргэж, хөтөлбөрийн тогтвортой байдлыг хангах элсэгч, суралцагчдад зориулсан хөтөч эмхэтгэлийг эрхлэн гаргадаг байна.

### **4-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

#### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Эм найруулагч хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд АШУҮИС-ийн 2023 оны 04 сарын 26 өдрийн А/109 тоот тушаал, АШУҮИС-ийн Дархан-Уул аймгийн АУС-ийн захирлын 2023 оны 05 сарын 15 өдрийн А/33 тоот тушаалын дагуу элсэгчдийг сонгон шалгаруулдаг.
- Эм найруулагч хөтөлбөрөөр 2017-2022 оны хичээлийн жилд 156 оюутан элсэн суралцсан бөгөөд 125 оюутан төгссөн. Эдгээр оюутнуудын элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноо хими-396, биологи-446 байна.

### **Онцлог зүйл:**

- Хичээлийн жил бүр “**Оюутны хөтөч**” гарын авлага шинээр гаргадаг. Үүнд, шинэ элсэгчидэд зориулан тухайн жилд зохион байгуулах сургалт, хүмүүжлийн ажлын төлөвлөгөө, сургалтын төлөвлөгөө, дүрэм, журам, удирдлага мэдээллийн системтэй ажиллах журам, АШУҮИС-ийн соёлын стандарт, тэтгэлэгт хамрагдах материалын жагсаалт, мэргэжилтний цогц чадамж зэргийг тусгасан.

### **Дүгнэлт:**

- Эм найруулагч хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд АШУҮИС-ийн 2023 оны 04 сарын 26 өдрийн А/109 тоот тушаал, АШУҮИС-ийн Дархан-Уул аймгийн АУС-ийн захирлын 2023 оны 05 сарын 15 өдрийн А/33 тоот тушаалын дагуу элсэгчдийг сонгон шалгаруулдаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажлын тайлангуудтай.
- Ажлын төлөвлөгөөндөө зохион байгуулах сургалтын чиглэлээ тодорхой тусгасан байна.
- Сургуулийн нэрэмжит тэтгэлэг, засаг даргын тамгийн газрын тэтгэлэг, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад сургалтын төлбөрийн зээл, дотуур байрны төлбөрөөс 100% чөлөөлөх зэрэг хөнгөлөлт дэмжлэг үзүүлдэг.
- “Оюутны хөдөлмөр эрхлэлтийн төв”-өөр дамжуулан Ажил олгогч эздийн холбоо, Хөдөлмөр халамж үйлчилгээний газартай хамтран ажиллах гэрээний хүрээнд 33 байгууллагад 59 оюутан 26,562,730 төгрөгийн ажил гүйцэтгэсэн. Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин “Орлоготой оюутан” төслийг хэрэгжүүлсэн. Эм найруулагч мэргэжлээр суралцаж буй төгсөх дамжааны оюутнууд ЭХНБ, эмийн сангуудад цалинтай дадлага хийсэн.

#### **Онцлог зүйл:**

- Багш нар оюутнуудыг нийгэм, олон нийтийн ажилд татан оруулах, идэвхжүүлэх, удирдан чиглүүлдэг бөгөөд сургуулийн захиргааны зүгээс багш, оюутны санаачлан зохион байгуулсан ажилд дэмжлэг үзүүлэн хамтран ажилладаг.
- Оюутанд сэтгэл зүйн зөвлөгөө тогтмол өгдөг.

#### **Дүгнэлт:**

Оюутанд чиглэсэн ажил мэргэжил, сэтгэл зүйн чиглэлээр зөвлөгөө өгдөг ба зөвлөн туслах үйлчилгээний төлөвлөгөөтэй ба төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан ажлын тайлантай.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн хэмжээнд оюутны 13 клуб үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь оюутны мэргэжлийн чиглэл, сонирхолд үндэслэн багш нар удирдан зохион байгуулдаг. Үүнээс Анагаах ухаан, Урлахуй, Сайн санаа-Сайхан сэтгэл, Спорт, Реторика, Food nutrition, Sora гэсэн клубууд тогтвортой үйл ажиллагаа явуулдаг. Анагаах ухаан, Урлахуй клуб нь эм найруулагчийн хөтөлбөрөөр суралцаж буй оюутнуудад чиглэн үйл ажиллагаагаа явуулдаг.

**Онцлог зүйл:**

- Эм найруулагч хөтөлбөрөөр суралцаж буй сургуулиудын оюутнуудын дунд “Оюутны ур чадварын тэмцээн” зохион байгуулсан /2018, 2019 он/
- Оюутанд чиглэсэн “Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төв”-тэй бөгөөд “Хүний хөгжил” цуврал сургалтыг зохион байгуулдаг. Эерэг хандлага-Эрүүл оюутан аяны хүрээнд Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт-93, гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөө-97, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг-276, гарын ариун цэвэр-97 оюутан тус тус хамрагдсан.

**Дүгнэлт:**

Суралцагчдыг нийгэм, олон нийтийн чиглэлээр үйл ажиллагаанд оролцох оролцоог болон санаачилсан сайн дурын ажлыг сургуулийн захиргаанаас дэмжиж багш нар хамтран ажилладаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оюутныг татан оролцуулах, боломжийг нэмэгдүүлэх, судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр оюутныг идэвхжүүлэх

**5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Багц цагийн дүйцэл, шилжилт хөдөлгөөний дүрэм журамтай.
- Журмын дагууд өөр сургууль болон гадаадаас ирсэн оюутны дүнг хүлээн зөвшөөрч багц цагийг дүйцүүлэн тооцох боломжийг бүрдүүлсэн байна.

**Дүгнэлт:**

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүн, багц цагийг дүйцүүлэн тооцох боломжийг холбогдох дүрэм, журмаар зохицуулан бүрдүүлсэн нь суралцагчийн эрх ашигт бүрэн нийцэж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэжил хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшинг тусгасан.

#### **Дүгнэлт:**

- Батлагдсан дүрэм, журмын дагуу төгсөлтийн баримт бичгийг олгодог.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**ДҮГНЭЛТ:** Эм найруулагч хөтөлбөрөөр оюутан элсүүлэхэд АШУҮИС-ийн захирлын А/109, А/33 тоот тушаалын дагуу элсэгчдийг сонгон шалгаруулдаг ба холбогдох дүрэм, журмын дагуу багц цагийг дүйцүүлэн тооцдог. Элсэгчдэд чиглэсэн ажил мэргэжил, сэтгэл зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлдэг бөгөөд оюутныг эрдэм шинжилгээний ажилд оролцуулах чиглэлээр ажилладаг.

**5-р шалгуурын нэгдсэн үнэлгээ:** Бүрэн хангасан.

### **Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

#### **6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн багш сонгон шалгаруулах журмын дагууд багшийг ажилд авж гэрээ байгуулан ажилладаг.
- Хөтөлбөрт 31 үндсэн багш ажиллаж, 22.5% нь доктор болон түүнээс дээш эрдмийн цол, зэрэгтэй.
- Сүүлийн 5 жилээр багш нарын ажилласан жил, эрдмийн зэрэг цолын судалгааг гаргасан байна.
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилсан урамшууллын тогтолцоотой.
- Багш нар сурган заах арга зүй, ур чадвар дээшлүүлэх сургалтанд хамрагддаг.
- Багшийн цагийн гүйцэтгэлийн нэгдсэн журмаар, онооны системээр тооцдог аргачлалтай.
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын ажилласан жилийг харахад 1-5 жил ажилласан багш 26%, 6-10 жил ажилласан багш 32%, 16-20 жил ажилласан багш 16%, 21-25 жил ажилласан багш 26% байна.
- 2022–2023 оны хичээлийн жилд эм найруулагч мэргэжлээр 99 оюутан суралцаж байгаа бөгөөд эм найруулагчийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 31 багш оролцсонтой харьцуулбал багш, оюутны харьцаа 1:3 байна.

#### **Онцлог зүйл:**

- АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, Багшийн аттестатчиллын шалгуур үнэлгээний дагуу багш нар сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл

ажиллагаа гэсэн ангиллаар өөрсдийн хийсэн ажлын тайланг жил бүр гаргаж, 3 жил тутамд багшийн аттестатчилалд хамрагддаг.

**Дүгнэлт:** Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй, дадлагажигч багш нарыг бэлтгэн ажиллаж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн хэмжээнд багш нараас цахим санал асуулга авч сургалтын хэрэгцээг тодорхойлдог.
- Салбар сургуулиудын багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд 100 сая төгрөгийн төсөвтэй 5 модуль сургалтыг явуулах хөтөлбөр төлөвлөгөө гарсгаснаас “Багшийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чадавхыг дээшлүүлэх”. “Сургалтын технологийн дэвшилтэт арга, хэлбэрүүд” сэдэвт сургалтууд зохион байгуулагдсан.
- АШУУИС-ийн Эм зүйн сургуульд Багш солилцооны хөтөлбөрийн дагууд мэргэжлийн тэнхмийн 4 багш ЭЗС-ийн 4 тэнхим, Эрдэм фарм эмийн үйлдвэр, МЯСЭ-ийн эмнэл зүйн албаны үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан.
- АШУУИС-ийн гадаад харилцааны бодлогын хүрээнд эрдэм шинжилгээ, багш, оюутан солилцоо, туршлага судлах үйл ажиллагааг дэмжих зорилгоор ижил түвшний 5 сургуультай хамтын ажиллагааны хүрээнд 23 багш, оюутныг БНХАУ, ОХУ, Тайланд, Франц, Сингапур, Япон, Солонгосын их дээд сургуульд мэргэжил дээшлүүлэх сургалт болон багш оюутан солилцооны хөтөлбөрт хамруулсан.

### **Онцлог зүйл:**

- Дархан-Уул сумын хэмжээнд их дээд сургуулиудын багш нарын дунд зохиогддог шилдэг заах арга зүйтэй багш шалгаруулах арга хэмжээнд багш нараас байнга оролцдог.
- “Шилдэг цахим хичээл”, “Шилдэг заах арга зүйч” “Шилдэг ном сурах бичиг, гарын авлага” шалгаруулах уралдааныг явуулж дүгнэдэг.

**Дүгнэлт:** Багшийн мэргэжил, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин, суралцах хэрэгцээг тодорхойлж багшийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд тодорхой төсөвийн хүрээнд төлөвлөсөн сургалтуудыг зохион байгуулж ажилладаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж:**

- Багш нарын гадаад хэлний мэдлэгийг сайжруулахад чиглэсэн сургалт дэмжлэгийг үзүүлж ажиллах

### **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Стратеги төлөвлөгөө-2030 хүрээнд багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрчимжүүлэх чиглэлээр судалгаанд зарцуулах зардлын эзлэх хувийг өсгөх, нэг багшид ноогдох WOS, Scopus, PubMed бүртгэлтэй мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд хэвлүүлсэн бүтээлийн тоо, илтгэлийн тоог ихэсгэх, хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийг нэмэгдүүлэх талаар зорьж эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөж ажилладаг.
- “Эм зүйн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлууд” ЭШХ-ыг 1 удаа зохион байгуулсан
- Эм зүйн холбооны үйл ажиллагааны хүрээнд эм зүйн байгууллагуудын төвийн бүсийн чуулганыг 2022 оны 3-р сард Дархан-Уул аймагт зохион байгуулж Улаанбаатар, Дархан-Уул, Сэлэнгэ, Булган, Орхон аймгуудын 60 орчим эм зүйн мэргэжилтнүүд оролцож холбооны дүрэм, журам, хуулийн шинэчлэлд оруулах саналыг хэлэлцсэн.
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд зарцуулсан төсөв жил бүр 0.5%-иар нэмэгдэж 5%-д хүрсэн.

#### **Онцлог зүйл:**

- “Эм зүйн тусламж, үйлчилгээний тулгамдсан асуудлууд” эрдэм шинжилгээ, онол практикийн бага хурлыг 2022 оны 9-р сарын 23-нд зохион байгуулсан.
- “Сайн санаа – Сайхан сэтгэл”, “Дээд боловсрол – Эрин үе” сэтгүүлүүдийг жилд 2 дугаарыг эрхлэн гаргаж багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажлаар бүтээлээ хэвлүүлэх боломжийг олгож ажилладаг.
- IF бүхий сэтгүүлд бүтээлээ хэвлүүлэхэд багш нарыг санхүүгээр дэмждэг.

**Дүгнэлт:** Багш нарын эрдэм шинжилгээ судалгааны ажил хийх, бүтээлээ хэвлэн нийтлүүлэх, хэлэлцүүлэх нөхцөл боломжийг дэмжиж, тогтмол сэтгүүл эрхлэн гаргаж хэвшсэн.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

#### **Зөвлөмж:**

- Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг улам чанаржуулах, инновацийн бүтээгдэхүүн гаргах чиглэлээр түлхүү хөгжүүлэх



#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн захирлын 2021 онд баталсан Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журмын 3-р бүлэг багшийн ажлын үнэлгээ ба багшлах эрхийг баталгаажуулах заалтын хүрээнд багш нарыг 3 жил тутамд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийж үр дүнг тооцдог.
- Багшийн өөрийн үнэлгээний тайланг үлгэрчилсэн шалгуурын дагуу үнэлдэг.
- 31 багшийн үнэлгээг тайланд тусгасан.
- Багшийн ажлын үнэлгээ нь багш албан тушаал ахих, хөдөлмөрийн гэрээг сунгах, цуцлах үндэслэл болдог.
- АШУҮИС-ийн багшийн хөгжил цахим сургалтын газрын ажлын хэсгээр хөндлөнгийн үнэлгээг хийдэг.

#### **Онцлог зүйл:**

- Сургалтын үйл ажиллагаатай холбоотой оюутны сэтгэл ханамжийн судалгааг 15 үзүүлэлтээр авч үр дүнг багш нэг бүрт илгээж түүн дээрээ анализ хийж ажилладаг.

**Дүгнэлт:** Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журмын дагууд багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хийсэн ажлуудыг хичээлийн жилийн эцэст үнэлж үр дүнг тооцож ажилладаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Дүгнэлт:** АШУҮИС-ийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам, Багшийн аттестатчиллын шалгуур үнэлгээний дагуу багш нар сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн ангиллаар ажлын тайланг жил бүр гаргаж, 3 жил тутамд багшийн аттестатчилалд хамрагддаг ба үүнтэй холбоотойгоор багш нарын бүхий л үйл ажиллагааны нотлох баримт, материал цэгцтэй болсон. Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлдэг, хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлэхэд хангалттай нөөц боломжтой ажиллаж байна.

**6-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

**Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн дэд хороо 2022 оны 11.16-ны өдөр байгуулагдсан.
- Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалтын удирдлага зохион байгуулалтын схемтэй.
- Хөтөлбөрийн дэд хороо сүүлийн 3 жилийн хугацаанд 2021-2023 оны хичээлийн жилд нийт 15 удаа хуралдсанаас эм найруулагчийн сургалтын хөтөлбөрийн шинэчлэлээр дараах агуулгаар 4 удаа хуралдаж шийдвэр гаргасан байна. (Мэргэжилтний цогц чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн тайлан, хэлэлцүүлгээс гаргасан зөвлөмж чиглэлүүдийг сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх (тухайлбал: англи хэлний чадварыг сайжруулах, эмийн бүртгэлийн цахим программуудыг эзэмшүүлэх чадварыг нэмэх зэрэг)

**Онцлог зүйл:**

- Чанарын 1 р баг буюу дотод аудит баг нь байгууллагын дотоод чанарын хяналтыг 10 гаруй чиглэлээр зохион байгуулж, дотоод хяналтын тайландаа илэрсэн алдаа, дутагдал, зөрчил, шийдвэрлэх асуудал, санал зөвлөмжийг тусган, захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, алдаа зөрчлийг тухай бүр арилгаж ажилладаг.
- Сургалтын хөтөлбөрийн оролцогч тал болон сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлээр бүх алба, тэнхимүүд хамтран ажилладаг. Төгсөгчдийн уулзалтыг жил бүр зохион байгуулдаг. Мэргэжлийн нийгэмлэг холбоодтой хамтран ажилладаг.

**Дүгнэлт:** Хөтөлбөрт оролцогч талуудаас авсан санал, зөвлөмжид тодорхой судалгаа хийж, нэгтгэх, хөтөлбөрийн сайжруулалтад тусгаж ажилладаг.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**Зөвлөмж**

- Хөтөлбөрийн дэд хорооны үйл ажиллагаа, хөтөлбөрийн үнэлгээг тогтмол хийж хэвших

**7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

**Илрэл нотолгоо:**

- Төгсөгчид болон ажил олгогчдоос IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх багийн боловсруулсан “Төгсөгчдийн мөшгөх судалгаа”, “Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа”-ны арга, аргачлалын дагуу 2017 оноос эхлэн тогтмол зохион байгуулан ажиллаж сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагыг хангасан мэргэжилтэн бэлтгэхийн тулд үйл ажиллагаандаа тусган ажилладаг. Мөн тэдэнтэй тогтмол уулзалт зохион байгуулж тэдний хэрэгцээ шаардлагыг нь тодорхойлдог.
- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгааг сүүлийн 5 жилээр гаргасан

- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн үнэлгээг Ликертийн 5 онооны хэмжүүрээр үнэлэхэд  $4.19 \pm 0.65$  буюу сайн гэж үнэлэгдсэн бөгөөд 68.7% нь сэтгэл ханамжтай, 18.8% дунд зэрэг, 12.5% нь сэтгэл ханамжгүй байна. Сэтгэл ханамжгүй байдлыг тандахад цалин, ажлын ачаалал, үйлчлүүлэгчийн харилцаа хандлага нөлөөлдөг гэж үзсэн байна.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт 90% гаруй хувьтай. Ажлын байраар хангагдах хүлээлгийн хугацаа жил ирэх бүр буурч байгаа.
- Оюутан, төгсөгчидтэй уулзахад өөртөө итгэлтэй, мэргэжилдээ сэтгэл хангалуун хангалуун байлаа.

**Онцлог зүйл:**

- Төгсөгчид, ажил олгогчдын санал дээр үндэслэн эмийн сан, эм хангамжийн байгууллагад зонхилон хэрэглэгддэг ОРИОН программыг хичээлийн хөтөлбөрт тусган оруулж сургалтын үйл ажиллагаанд ашигладаг болсон нь сайшаалтай байв.

**Дүгнэлт:** Төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, эм хангамжийн байгууллагад ажиллах цогц чадамжтай төгсөж чадаж байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

**7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

**Илрэл нотолгоо:**

- Тус хөтөлбөрийг үндэсний болон олон улсын хэмжээнд магадлан итгэмжлүүлээгүй. Анх удаа үндэсний хэмжээнд магадлан итгэмжлүүлэхээр ажиллаж байгаа.
- Шаталсан сургалтын 3+3 хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох шалгалтын амжилт дунджаар 94% байна.

**Онцлог зүйл:**

- Ажил олгогч, төгсөгчдийн төлөөллийг оролцуулан хөтөлбөр дээр санал авч хамтран ажилладаг.
- Мэргэшүүлэх дадлагыг орон нутгийн эмийн сан болон УБ хотод Нахиа, Тавин-Ус Эмийн үйлдвэрийг түшиглэн явуулж эхэлсэн.

**Дүгнэлт:**

Хөтөлбөрийг анх удаа БМИҮЗ-өөр итгэмжлүүлэхээр ажиллаж байгаа бөгөөд төгсөгчид дотооддоо эм найруулагчийн цогц чадамжид суралцаж ажил олгогчдын захиалгад нийцэж байна гэсэн дүгнэлтийг өгч байна.

**Үнэлгээ:** Бүрэн хангасан

Хөтөлбөрт үнэлгээ хийх, оролцогч талуудын саналыг тусган ажилладаг, төгсөгчдийн ажил эрхлэлт, ажлын байрны нийцэл, карьерийн өсөлтийн судалгааг хийж үр дүнг хөтөлбөрт тусган ажиллаж эхэлсэн бөгөөд цаашид судалгааг тогтмолжуулах нь зүйтэй гэж үзлээ.

### 7-р шалгуурын нэгдсэн үнэлгээ: Бүрэн хангасан

#### ДҮГНЭЛТ

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгч лэн хангасан	Хангаа гүй (0)	Үндэслэл, шалтгаан /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал бичнэ/
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Бүрэн хангасан
2	Сургалтын үйл ажиллагаа	3			Бүрэн хангасан
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	3			Бүрэн хангасан
4	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	5			Бүрэн хангасан
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			Бүрэн хангасан
6	Багшийн үйл ажиллагаа	4			Бүрэн хангасан
7	Чанарын үнэлгээ, баталгаажилт	3			Бүрэн хангасан
	Нийт	26			
<b>Дүгнэлт</b>		<b>Бүрэн хангасан</b>			

## НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ, ШААРДЛАГА

Сургуулийн нэр	АШУҮИС, Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль
Хөтөлбөрийн нэр	Эм найруулагч
Хөтөлбөрийн индекс	091602 дипломын хөтөлбөр
<b>ЗӨВЛӨМЖ</b>	
Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн хэрэгцээнд хөдөлмөрийн зах зээлийн барометрийн судалгааг хийж байх</li> <li>- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг харуулсан шинжилгээг илүү нарийвчлан хийх (STEEP шинжилгээ хийх)</li> </ul>
Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, хичээлийн хүрэх үр дүнгийн уялдаа холбоог сайжруулах</li> <li>- Эм найруулагчийн хөтөлбөрийн матрицийг ойлгомжтой байдлаар томъёолох</li> </ul>
Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөөц	<ul style="list-style-type: none"> <li>- Лабораторийн тоног төхөөрөмж, багажийн ашиглалт, паспорт хөтлөлт бүртгэлжүүлэлтийг тогтмол хийх, багаж тоног төхөөрөмж ашиглах аюулгүй ажиллагааны дүрмийг байршуулах</li> <li>- Эмийн технологи гэх мэт дадлагын хичээлийн явцад хийгдсэн бүтээгдэхүүнд чанар стандартын дагууд үнэлгээ хийх, технологийн горимыг сайжруулах тал дээр багш нар хяналт тавьж ажиллах</li> <li>- Орион программ бүхий компьютерийн хангамжийг нэмэгдүүлэх</li> <li>- Сургуулийн орчинд чөлөөт wifi интернет ашиглах боломжийг нэмэгдүүлэх</li> </ul>
Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	<ul style="list-style-type: none"> <li>- Ажил олгогчийн саналыг хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтанд тусгах, эргэх холбоотой ажиллах тогтолцоог бүрдүүлэх</li> <li>- Санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал, суралцагчийн сургалтын төлбөрөөс хамааралтай байгаа тул эм найруулагч хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж оюутны сургалтын төлбөрөөс бусад санхүүгийн эх үүсвэрүүдийг бий болгох (сургалт, эрдэм шинжилгээний төсөл, төсөлт хөтөлбөр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй хамтын ажиллагааг хөгжүүлэх зэрэг)</li> <li>- Эм найруулагч хөтөлбөрөөр маркетингийн идэвхижүүлэлтийг тогтмол хийх, тодорхой хэмжээний санхүүжилтийг жил бүр тусгаж ажиллах</li> </ul>
Шалгуур 5. Суралцагчдад чиглэсэн үйлчилгээ	<ul style="list-style-type: none"> <li>- Эрдэм шинжилгээ судалгааны ажилд оюутныг татан оролцуулах, боломжийг нэмэгдүүлэх, судалгаа, шинжилгээний ажлын чиглэлээр оюутныг идэвхжүүлэх</li> </ul>
Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> <li>- Багш нарын эрдэм шинжилгээний ажлыг улам чанаржуулах, инновацын бүтээгдэхүүн гаргах чиглэлээр түлхүү хөгжүүлэх</li> </ul>

Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт	- Хөтөлбөрийн дэд хорооны ажлын төлөвлөгөөний дагуу хөтөлбөрийн үнэлгээг тогтмол хийж хэвших
<b>ШААРДЛАГА:</b> /хэсэгчлэн хангасан болон хангаагүй шалгуурт заавал шаардлага бичнэ/	
	-

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУҮИС, Дархан-Уул аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн “Эм найруулагч” - 091602 хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг..... Ц.Мөнхтуяа

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... Б.Цэрэндолгор

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг..... С.Идэртунгалаг

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### Багш нартай хийсэн уулзалт

**Огноо:** 2022.05.30-ны 15.00-16.00 цаг

**Хаана:** Эрдмийн өргөө, А201

№	Овог	Нэр	Албан тушаалын зэрэг	Заадаг хичээл	Утас
1	Дашзэвэг	Мөнх-Эрдэнэ	Ахлах багш, Доктор	Эмийн хими I II III, Эмийн эрх зүй,	99081855
2	Баяраа	Мэндхүү	Ахлах багш, дэд профессор	Анатоми	99700232
3	Хусман	Оюунгэрэл	Ахлах багш	Эм судлал, клиник эм судлал	99394839
4	Батром	Хулан	Багш	Эмийн үйлдвэрийн технологи, Эмийн технологи, Харилцааны ур чадвар, Сэтгэл судлал	99860063
5	Бямбаа	Оюунчимэг	Багш	Бичил амь судлал	99379752
6	Цогтсайхан	Адьяахатан	Багш	Физиологи	99833603
7	Гомбожав	Цэндмаа	Багш	Гистологи	99663162
8	Энхболд	Энхзаяа	Дадлагажигч багш	Биохими	80089703
9	Баянжаргал	Ариунжаргал	Дадлагажигч багш	Эмгэг судлал	99215734
10	Хүрэлбаатар	Өлзийжаргал	Дадлагжигч багш	Эмийн зах зээл, зохион байгуулалт, бүртгэл тооцоо	99732222
11	Цогтжаргал	Мөнхнаран	Гэрээт багш	Анатоми	90477370
12	Одонбаатар	Оюунсүрэн	Гэрээт багш	Лаборатори	99395373
13	Гантогоо	Мөнхмандах	Гэрээт багш	Эм судлал, Латин хэл	94389917
14	Чадраабал	Жадамба	Гэрээт багш	Лаборатори	85822999
15	Буяндалай	Ариунболд	Хичээлийн туслах ажилтан		99373505
16	Цэрэндаш	Болормаа	Ахлах багш	Аналитик хими	94388868
17	Гүрбазар	Ууганцэцэг	Ахлах багш	Монгол эм судлал	99398593

##### 2. Ажил олгогчдын төлөөлөлтэй хийсэн уулзалт

**Огноо:** 2023.05.30-ны 11.00 цаг

Join Zoom Meeting

<https://us06web.zoom.us/j/82857073859?pwd=djRMQ2MvT1o0bVBRy2hxYnZ4MGIZdz09>

Meeting ID: 828 5707 3859

Passcode: 983738

№	Овог нэр	Байгууллага, албан тушаал	утас	Гарын үсэг
1	М.Энхцэцэг	Өлзий-Амгалан ХХК, захирал	99372148	
2	Б.Содончимэг	Монос Дархан салбарын эрхлэгч	99031185	

3	Г.Билэгмаа	Онон эмийн сангийн эрхлэгч	99396488	
4	М.Сарангуа	Монос Булган салбарын эрхлэгч	80010884	
5	Э.Золзаяа	Монос орон нутаг хариуцсан менежер	86086363	
6	Ц.Эрдэнэчимэг	Сэлэнгэ аймаг, Нэгдсэн эмнэлгийн дарга	99034645	
7	Т.Аззаяа	МЭИК-ны Дархан-Уул аймаг дахь салбарын захирал	94947005	
8	Л.Энхтуяа	Хэрлэн эмийн сангийн эрхлэгч	99017912	
9	Б.Отгонням	Мөнхийн тун Дархан салбарын захирал	99656944	
10	М.Ганзолбоо	МЭИК-ны Сэлэнгэ аймаг дахь салбарын захирал	99637863	
11	А.Дэлгэрмаа	Дархан-Уул аймаг, НЭ-ийн эм зүйн албаны дарга	99940913	
12	Н.Байгальмаа	Содфарм ХХК-ны захирал	99395452	
13	Н.Ариунтуяа	Азифарм Дархан салбарын захирал	99767104	
14	С.Сарангэрэл	Цахиур төмөр ХХК, Дархан салбарын эрхлэгч	94929979	
15	Б.Мөнхтунгалаг	Шижирням ХХК-ны захирал	99028008	
16	Г.Мөнхцэцэг	Энхфарм эмийн сангийн эрхлэгч	99971129	
17	Нандинцэцэг	Орхон аймаг	99619103	
18	Д.Отгонжаргал	Ариунмонгол ХХК, эм зүйч	95099581	
19	Д.Ундармаа	Анагаах тун эмийн сангийн эрхлэгч	99794749	
20	Ч.Дангаасүрэн	Монфа ХХК, Дархан салбар	99376055	



**Оюутны төлөөлөлтэй хийсэн уулзалт****Огноо: 2023.05.31-ны 14.00 цаг****Хаана: хичээлийн А байр, эрдмийн өргөө №201**

№	Оюутны овог нэр	Дамжаа	Сонгосон байдал	Утас	Гарын үсэг
1	Гансүх Алтанболор	ЭН-1	Цахим	99782887	
2	Янжмаа Отгонцэцэг	ЭН-1	Цахим	88059685	
3	Мижиддорж Отгондэмид	ЭН-1	Цахим	99000467	
4	Оросоо Солонго	ЭН-1	Цахим	99003217	
5	Баянмөнх Намду	ЭН-1	Цахим	80620244	
6	Алдархишиг Ариунчимэг	ЭН-1	Танхим	95371077	
7	Батцоож Номин	ЭН-1	Танхим	99408178	
8	Батхуяг Нямсүрэн	ЭН-1	Цахим	85606597	
9	Алтансүх Саранжавхаа	ЭН-1	Танхим	99301350	
10	Бандандорж Нарангэрэл	ЭН-1	Танхим	90111319	
11	Эрдэнэсан Нүрзэд	ЭН-1	Танхим	80814487	
12	Загираа Соёл Эрдэнэ	ЭН-1	Танхим	99318010	
13	Гансүх Бяарцэцэг	ЭН-1	Танхим	99793303	
14	Д.Отгончимэг	ЭН-2	Танхим	99075605	
15	Б.Оюунзул	ЭН-2	Цахим	90120051	
16	Т.Эрдэнэбямба	ЭН-2	Танхим	90165515	
17	Ш.Одончимэг	ЭН-2	Цахим	88031487	
18	Б.Ганчимэг	ЭН-2	Цахим	86661633	
19	П.Баясгалан	ЭН-2	Цахим	85159575	
20	Э.Чимэдцогзол	ЭН-2	Танхим	99291026	
21	Д.Даваасүрэн	ЭН-2	Танхим	95756965	
22	С.Булган	ЭН-2	Танхим	86242070	
23	Э.Энхзул	ЭН-3	Цахим	88453404	
24	Б.Болортуяа	ЭН-3	Цахим		

**ТӨГСӨГЧДИЙН ТӨЛӨӨЛӨЛ****Огноо: 2023.05.31-ны 10.00 цаг**

№	Төгсөгчийн нэр	Төгссөн он	Байгууллага, албан тушаал	Утас	e-mail
1.	Б.Тулга	2016	Монос	99576275	Групп нээсэн
2.	М.Аюуш	2015	Монос	88087582	
3.	Т.Төмөрхүлэг	2016	Монос	95378090	
4.	З.Номин	2019	Монфа	95796945	
5.	М.Жаргалсайхан	2019	Энх фарм	99963924	
6.	Т.Дэлгэрцэцэг	2019	Мишээл	95725932	
7.	Г.Үүрцайх	2019	Энхфарм	86631233	
8.	М.Намжаа	2013	Монос	99220656	
9.	С.Золжаргал	2014	Мөнхийн тун	85300001	
10.	П.Эрдэнэцэцэг	2014	Монос	99851286	
11.	Э.Амарзаяа	2022	Хүслэн		
12.	Э.Сарангоо	2022	Өлзий Амгалан		
13.	С.Өлзийсайхан	2013	Анагаах тун	88101597, 99964100	
14.	А.Алтансүвд	2016	Монос	88668863	
15.	Ж.Анхзаяа	2010	Монос	944457575	
16.	С.Мөнхзаяа	2003	Монос	99215969	
17.	П.Түмэнцэцэг	2013	Бялхам		
18.	Т.Алтанзул	2019	Монос		
19.	Х.Оюунчимэг	2003	Монос		
20.	Д.Хүрэлтуяа	2009	Монос		

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**АШУУИС**

**АШУУИС-ИЙН ДАРХАН-УУЛ  
АЙМАГ САЛБАР  
АНАГААХ УХААНЫ СУРГУУЛЬ**

13 дугаар баг, Дархан сум,  
Дархан-Уул аймаг, 45051  
Утас: 70377734

Цахим шуудан: darkhanuul@mnums.edu.mn  
2023.06.16 № 168  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛД**

Хүсэлт гаргах тухай

Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн ажлын албаны захирлын 2023 оны А/139 тоот тушаалаар томилогдсон шинжээчийн баг тус сургууль дээр 2023 оны 05 дугаар сарын 30,31-ны өдрүүдэд ажиллаж "Эм найруулагч" 091602 дипломын хөтөлбөрийн өөрийн үнэлгээний тайлан, шалгуурын дагуу илрэл, нотлох баримттай танилцаж хөндлөнгийн үнэлгээ хийсэн болно. Шинжээчийн хөндлөнгийн үнэлгээний тайланг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдөр хүлээн авч хөндлөнгийн үнэлгээ хийсэн тухай шинжээчийн тайлантай танилцаж бид хүлээн зөвшөөрч байна.

ЗАХИРАЛ



Б.БАЯСГАЛАНМӨНХ

A4 2023 он.docx